НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/060/НА-СТА-ОНӨҮГ

Дарга, Тэргүүлэх аудитор:
Г.Нандинжаргал
Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер:
Х.Түвшинбаяр
Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: С.Гантөгс
Утас: 315558 Цахим хаяг: gantugs.s@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн : Ай Жэй Эй Эйч аудит ХХК
Захирал: Г.Энхмаа
Утас: 99040059 Цахим хаяг:ijahaudit2020@gmail.com

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар
2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА 9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа 9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд 10
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл 11
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин 11
3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл 14
3.5.4 Худалдан авах ажиллагааны бүртгэл 14
4. АУДИТЫН ТАЙЛАН 15
4.1 Ерөнхий зүйл 15
4.2 Материаллаг байдал **15**
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал **15**
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт **16**
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд 16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал **17**
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 18
5.2 АЛБАН ШААРДЛАГА 18
5.3 ЗӨВЛӨМЖ 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ 20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.03.13 № 850

танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР,
АРЧЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Т.БАТБИЛЭГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар зам засвар, арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь Замын сангийн хөрөнгөөс 43,078.3 сая төгрөг, Нийслэлийн засаг даргын нөөц сангаас 2,539.7 сая төгрөгийн санхүүжилтийг авч 31 төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргын тамгын газартай 13 гэрээт ажил, Нийслэлийн Авто замын хөгжлийн газартай 18 гэрээт ажил хийж 96.0 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өгсөн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

C:\Users\marangua [Desktop\Бичиг хэрэг 2026\2026 оны аудитын тайлан\Улаанбаатар зам засвар арчлалтын газар\1426950917

1426950917

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.l\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\Dugnelt 2026.docx

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	2024 оны 12 сарын 31	2025 оны 12 сарын 31
1	**ХӨРӨНГӨ**	**-**	**-**
1.1	**Эргэлтийн хөрөнгө**	**-**	**-**
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	2,280,757,185.23	605,312,766.05
1.1.2	Дансны авлага	30,576,690,987.83	3,835,732,249.27
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	158,399.62	63,970.23
1.1.4	Бусад авлага	2,182,841,930.50	1,840,597,034.50
1.1.6	Бараа материал	4,946,954,070.88	5,099,158,347.24
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	5,712,972,727.27	2,633,692,309.17
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	18,821,566.83	20,576,380.70
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**45,719,196,868.16**	**14,035,133,057.16**
1.2	**Эргэлтийн бус хөрөнгө**	**-**	**-**
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,348,792,800.39	4,181,850,129.40
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**3,348,792,800.39**	**4,181,850,129.40**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**49,067,989,668.55**	**18,216,983,186.56**
2.1.1.1	Дансны өглөг	462,014,103.52	1,070,747,899.98
2.1.1.3	Татварын өр	4,520,965,988.85	5,172,317,954.52
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	33,058,048,179.09	-
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	1,802,432,703.17	1,588,947,979.47
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	84,133,760.10	-
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**39,927,594,734.73**	**7,832,013,833.97**
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	**-**	1,475,498,000.00
2.1.2.6	**Урт хугацаат өр төлбөрийн дүн**	**-**	**1,475,498,000.00**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**39,927,594,734.73**	**9,307,511,833.97**
2.3.1	Төрийн өмч	7,765,127,992.86	7,765,127,992.86
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,167,698,193.21	1,167,698,193.21
2.3.9	Хуримтлагдсан ашиг	207,568,747.75	(23,354,833.48)
2.3.11	**Эздийн өмчийн дүн**	**9,140,394,933.82**	**8,909,471,352.59**
2.4	**ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ**	**49,067,989,668.55**	**18,216,983,186.56**

2.2 Аудит хийсэн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	39,395,058,567.14	46,473,153,425.73
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	37,943,637,657.84	45,064,689,346.31
3	**Нийт ашиг/алдагдал/**	**1,451,420,909.30**	**1,408,464,079.42**
9	Хүүний орлого	20,606,410.86	26,356,130.75
10	Бусад орлого	23,782,131.11	36,842,442.68
12	Ерөнхий ба удирдлагын зардал	1,196,243,091.80	1,366,102,087.92
13	Санхүүгийн зардал	1,874,523.18	1,939,357.11
14	Бусад зардал	254,816,269.90	77,014,799.09
20	**Татвар төлөхийн өмнөх ашиг/ алдагдал/**	**42,875,566.39**	**26,606,408.73**
21	**Орлогын албан татварын зардал**	6,078,526.64	2,645,000.00
22	**Татварын дараах ашиг алдагдал**	**36,797,039.75**	**23,961,408.73**
24	**Тайлант үеийн цэвэр ашиг/ алдагдал/**	**36,797,039.75**	**23,961,408.73**

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	**2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**7,765,127,992.86**	**1,167,698,193.21**	**170,771,708.00**	**9,103,597,894.07**
2	Залруулсан үлдэгдэл	7,765,127,992.86	1,167,698,193.21	170,771,708.00	**9,103,597,894.07**
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	36,797,039.75	**36,797,039.75**
4	**2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**7,765,127,992.86**	**1,167,698,193.21**	**207,568,747.75**	**9,140,394,933.82**
5	Залруулсан үлдэгдэл	7,765,127,992.86	1,167,698,193.21	207,568,747.75	**9,140,394,933.82**
6	Өмчид гаргасан өөрчлөлт	-	-	(237,520,339.96)	**(237,520,339.96)**
7	Зарласан ногдол ашиг	-	-	(17,364,650.00)	**(17,364,650.00)**
8	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	23,961,408.73	**23,961,408.73**
9	**2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл**	**7,765,127,992.86**	**1,167,698,193.21**	**(23,354,833.48)**	**8,909,471,352.59**

2.4 **Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**		
1.1	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)**	**49,669,515,132.48**	**44,202,094,435.80**
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	49,648,150,766.31	44,165,473,993.12
1.1.4	Бусад мөнгөн орлого	21,364,366.17	36,620,442.68
1.2	**Мөнгөн зарлагын дүн**	**51,109,302,732.09**	**45,886,530,335.73**
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,456,391,154.00	3,189,242,622.04
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	745,987,210.00	980,516,541.85
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	46,468,328,402.96	37,123,451,781.20
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	89,672,991.42	356,578,110.96
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	2,820,000.00	1,710,363.64
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	344,027,061.09	271,431,032.66
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	9,822,127.00	242,862.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	992,253,785.62	3,963,357,021.38
1.3	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)**	**(1,439,787,599.61)**	**(1,684,435,899.93)**
2	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**		
2.1	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)**	**20,606,410.86**	**26,356,130.75**
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	20,606,410.86	26,356,130.75
2.2	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)**	**-**	**-**
2.3	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)**	**20,606,410.86**	**26,356,130.75**
3	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**	**-**	**-**
3.1	**Мөнгөн орлогын дүн**	-	-
3.2	**Мөнгөн зарлагын дүн**	**-**	**17,364,650.00**
3.2.4	Төлсөн ногдол ашиг		17,364,650.00
3.3	**САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**		(17,364,650.00)
4	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)**	**(1,419,181,188.75)**	**(1,675,444,419.18)**
5	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**		**2,280,757,185.23**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**		**605,312,766.05**

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/2025гүйц	Хувь	2025 төл/2025гүйц	Хувь
Авто зам, замын байгууламж барих, засвар, арчлалтын ажил	34,033,252.3	45,589,243.9	45,341,040.1	11,307,787.8	24.9	(248,203.8)	(0.5)
Сургууль орчмын хөдөлгөөний аюулгүй байдал	2,823,342.8	560,000.0	-	(2,823,342.8)		(560,000.0)	
Хайс, хашлаганы засвар арчлалт	1,038,227.6	-	-	(1,038,227.6)		-	
Гүүрийн байгууламж, нүхэн гарцны ашиглалт үйлчилгээ	395,717.8	699,907.3	619,731.3	224,013.5	36.1	(80,176.0)	(12.9)
Асфальт бетон хольц үйлдвэрлэлтийн орлого	1,022,691.3	300,000.0	443,445.0	(579,246.3)	(130.6)	143,445.0	32.3
Төлбөртэй авто зогсоолын орлого	17,253.0	-	-	(17,253.0)		-	
Бусад орлого	108,962.3	-	132,135.6	23,173.3	17.5	132,135.6	100.0
Нийт орлогын дүн	**39,439,447.1**	**47,149,151.2**	**46,536,352.0**	**7,096,904.9**	**15.3**	**(612,799.2)**	**(1.3)**
Цалин	2,913,875.0	5,072,131.1	3,890,562.5	976,687.5	133.5	(1,181,568.6)	(30.4)
Хоол унааны хөнгөлөлтийн зардал	188,271.0	509,112.0	237,714.0	49,443.0	126.3	(271,398.0)	(114.2)
Нийгмийн даатгалын шимтгэл	404,382.4	719,980.4	534,892.6	130,510.2	132.3	(185,087.8)	(34.6)
Удирдах зөвлөлийн зардал	29,700.0	64,380.1	-	(29,700.0)	-	(64,380.1)	
Сэлбэг хэрэгсэл	239,738.0	296,758.4	279,098.7	39,360.7	116.4	(17,659.7)	(6.3)
Ашиглалтын зардал	123,481.7	128,040.0	133,168.6	9,686.9	107.8	5,128.6	3.9
Түрээсийн зардал	680,831.3	1,200,000.0	4,044,685.4	3,363,854.1	594.1	2,844,685.4	70.3
Тос, тосолгооны зардал	81,406.6	89,639.0	68,831.1	(12,575.5)	84.6	(20,807.9)	(30.2)
Хөдөлмөр хамгаалалын зардал	33,490.0	34,760.0	22,391.9	(11,098.1)	66.9	(12,368.1)	(55.2)
Түүхий эд материал	3,488,401.5	5,076,970.0	4,054,263.9	565,862.4	116.2	(1,022,706.1)	(25.2)
Урсгал засварын зардал	13,698.9	180,000.0	40,000.0	26,301.1	292.0	(140,000.0)	(350.0)
Шатахуун	1,306,417.7	1,492,105.0	1,289,912.9	(16,504.8)	98.7	(202,192.1)	(15.7)
Шуудан холбоо, бичиг хэрэгсэл	15,857.4	31,283.0	29,355.3	13,497.9	185.1	(1,927.7)	(6.6)
Сургалт	17,890.0	10,210.0	7,195.0	(10,695.0)	40.2	(3,015.0)	(41.9)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	869,637.5	873,875.3	624,787.9	(244,849.6)	71.8	(249,087.4)	(39.9)
Албан журмын даатгал, татвар	24,927.2	37,000.0	21,395.8	(3,531.4)	85.8	(15,604.2)	(72.9)
Хангамжийн материал	40,432.9	46,118.8	27,354.5	(13,078.4)	67.7	(18,764.3)	(68.6)
Нийгмийн арга хэмжээний зардал	189,610.5	223,000.0	48,078.6	(141,531.9)	25.4	(174,921.4)	(363.8)
Ахмадын сан	33,583.0	50,721.3	13,600.0	(19,983.0)	40.5	(37,121.3)	(273.0)
Зар сурталчилгаа	-	5,500.0	1,500.0	1,500.0		(4,000.0)	(266.7)

Он дамнасан ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	28,655,142.2	25,937,307.4	21,260,509.3	(7,394,632.9)	74.2	(4,676,798.1)	(22.0)
2025 оны гэрээт ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	-	4,941,700.0	9,842,522.6	9,842,522.6		4,900,822.6	49.8
Гамшгийн үеийн менежментийн зардал	23,560.0	24,025.0	19,025.0	(4,535.0)	80.8	(5,000.0)	(26.3)
Үйл ажиллагааны бус зардал	22,236.7	60,000.0	18,900.0	(3,336.7)	85.0	(41,100.0)	(217.5)
Нийт зардлын дүн	**39,396,571.5**	**47,104,616.8**	**46,509,745.6**	**7,113,174.1**	**118.1**	**(594,871.2)**	**(1.3)**
Татварын өмнөх ашиг	**42,875.6**	**44,534.5**	**26,606.4**	**(16,269.2)**	**62.1**	(17,928.1)	**(67.4)**
Орлогын татвар	6,078.6	4,453.5	2,645.0	(3,433.6)	43.5	(1,808.5)	(68.4)
Цэвэр ашиг, алдагдал	**36,797.0**	**40,081.1**	**23,961.4**	**(12,835.6)**	**65.1**	(16,119.7)	**(67.3)**
Орлогын нэг төгрөгт ногдох зардал	**1.0**	**1.0**	**1.0**	(0.0)	99.9	(0.0)	(0.0)
Нийт авлага	4,000,283.0	3,123,383.0	8,042,833.3	4,042,550.3	201.1	4,919,450.3	61.2
Нийт өр төлбөр	4,021,017.0	4,348,160.0	7,502,261.5	3,481,244.5	186.6	3,154,101.5	42.0
Хөрөнгө орулалт	560,000.0	712,000.0		(560,000.0)		(712,000.0)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар арчлалт, хамгаалалт, замын тэмдэг, тэмдэглэгээ, асфальт бетон, бетон бүтээц эдлэл, хайрга дайргын үйлдвэрлэл, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн засвар арчлалт, ашиглалтыг хариуцах чиг үүрэг бүхий орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн" гэж тодорхойлжээ.

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын зорилго нь "Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн засвар, арчлалт, хамгаалалт, замын тэмдэг тэмдэглэгээ, асфальт бетон, бетон бүтээц эдлэл, хайрга, дайрганы үйлдвэрлэл, нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн засвар, арчлалт, ашиглалтыг хариуцах ажлуудыг холбогдох хууль тогтоомж, норм стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэх замаар нийтийн эзэмшлийн буюу Улаанбаатар хотын авто зам, замын байгууламжийн ашиглалт, засвар үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх"-д оршино гэж заасан байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Нийслэл өмчийг 100 хувийг эзэмшиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Архивын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Авто замын тухай хууль, Авто зам, замын байгууламжийн засвар, засвар арчлалтын ажлын техникийн шаардлага, Монгол улсын Нийслэл Улаанбаатар эрх зүйн байдлын тухай хуулиудыг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 сарын 07-ний өдрийн 03 дугаар "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоолын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 1-ний өдрөөс хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 792.0 мянган төгрөгөөр тогтоосон;
- Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд 2025 оны 07 дугаар сарын 9-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй ба нийслэлийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын газраас хяналтыг хэрэгжүүлдэг. Нийслэлийн дотоод

аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ нь 2024 онд баталсан Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.
Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 30,851,006.5 мянган төгрөгөөр буюу 37.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	**1**	**2**	**3=2-1**
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2,280,757.19	605,312.77	(1,675,444.42)
Дансны авлага	32,759,691.32	5,676,393.25	(27,083,298.06)
Бараа материал	4,946,954.07	5,099,158.35	152,204.28
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,712,972.73	2,633,692.31	(3,079,280.42)
Бусад эргэлтийн хөрөнгө	18,821.57	20,576.38	1,754.81
Үндсэн хөрөнгө	3,348,792.80	4,181,850.13	833,057.33
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	**49,067,989.67**	**18,216,983.19**	**(30,851,006.48)**
Өр төлбөрийн дүн	39,927,594.73	9,307,511.83	(30,620,082.90)
Эздийн өмчийн дүн	9,140,394.93	8,909,471.35	(230,923.58)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	**49,067,989.67**	**18,216,983.19**	**(30,851,006.48)**

Дээрх хүснэгтээс харахад: өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн дансуудад байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь “Сургууль орчмын хөдөлгөөний аюулгүй байдал”-ын гэрээт ажил хэрэгжээгүйгээс шалтгаалан арилжааны банкны харилцах дансанд байршиж байна.

Авлагын дансны үлдэгдэл нь 27,083,298.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны гэрээт ажлын авлагыг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл нь 5,099,158.4 мянган төгрөг болж 152,204.3 мянган мянган төгрөгөөр өссөн нь 12,060,412.0 мянган мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үйл ажиллагаанд 11,968,952.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас;

Урьдчилж төлсөн зардал тооцоо дансны үлдэгдэл 2,633,692.3 мянган төгрөг болж 3,079,280.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл нь 4,181,850.1 мянган төгрөг болж 833,057.3 мянган төгрөгөөр өссөн нь Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1528 тоот захирамжаар 1,410,498.0 мянган төгрөгийн 5 тээврийн хэрэгслийг өөрийн өмчид бүртгэж, А/473 тоот захирамжаар 184,330.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг орлогодож, 10,550.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг капиталжуулж, 2025 оны А/1522 дугаар захирамжаар 1,224,670.8 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас баланст шилжүүлж, 624,787.9 мянган төгрөгийн тайлант хугацааны хуримтлагдсан элэгдэл бүртгэсэнээс;

Өр төлбөрийн үлдэгдэл 9,307,511.8 мянган төгрөг болж 30,620,082.9 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд бүртгэгдсэн урьдчилж орсон орлогыг борлуулалтын орлогоор хүлээн зөвшөөрч, 1,588,948.0 мянган төгрөгийн барьцаа байршуулж, 1,475,498.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрсөн зэргээс;

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 8,909,471.4 мянган төгрөг болж 230,923.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 17,364.7 мянган төгрөгийн ногдол ашгийг төвлөрүүлж, 237,520.3 мянган төгрөгийн өмчид гарсан өөрчлөлт, 23,961.4 мянган төгрөгийн ашигтай ажилласан зэргээс тус тус шалтгаалсан байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын дарга нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийслэлийн засаг даргын 2025 оны А/92 тоот тушаалаар 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 47,149,151.2 мянган төгрөгөөр, нийт зардлыг 47,090,391.3 мянган төгрөгөөр, 58,759.9 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 712,000.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Хүснэгт 2. Орлогын үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:		**Төлөв**	**Гүйц**	**2024 гүйц/2025гүйц**	**Хувь**	**2025 төл/2025гүйц**	**Хувь**

Авто зам, замын байгууламж барих, засвар, арчлалтын ажил	34,033,252.3	45,589,243.9	45,341,040.1	11,307,787.8	24.9	(248,203.8)	(0.5)
Сургууль орчмын хөдөлгөөний аюулгүй байдал	2,823,342.8	560,000.0	-	(2,823,342.8)		(560,000.0)	(1.2)
Хайс, хашлаганы засвар арчлалт	1,038,227.6	-	-	(1,038,227.6)		-	-
Гүүрийн байгууламж, нүхэн гарцны ашиглалт үйлчилгээ	395,717.8	699,907.3	619,731.3	224,013.5	36.1	(80,176.0)	(0.2)
Асфальт бетон хольц үйлдвэрлэлтийн орлого	1,022,691.3	300,000.0	443,445.0	(579,246.3)	(130.6)	143,445.0	0.3
Төлбөртэй авто зогсоолын орлого	17,253.0	-	-	(17,253.0)		-	-
Бусад орлого	108,962.3	-	132,135.6	23,173.3	17.5	132,135.6	0.3
Нийт орлогын дүн	**39,439,447.1**	**47,149,151.2**	**46,536,352.0**	**7,096,904.9**	**15.3**	**(612,799.2)**	**(1.3)**

Хүснэгт 3. Зардлын үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 он		Харьцуулалт			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 гүйц/2025гүйц	Хувь	2025 төл/2025гүйц	Хувь
Цалин	2,913,875.0	5,072,131.1	3,890,562.5	976,687.5	133.5	(1,181,568.6)	(30.4)
Хоол унааны хөнгөлөлтийн зардал	188,271.0	509,112.0	237,714.0	49,443.0	126.3	(271,398.0)	(114.2)
Нийгмийн даатгалын шимтгэл	404,382.4	719,980.4	534,892.6	130,510.2	132.3	(185,087.8)	(34.6)
Удирдах зөвлөлийн зардал	29,700.0	64,380.1	-	(29,700.0)	-	(64,380.1)	
Сэлбэг хэрэгсэл	239,738.0	296,758.4	279,098.7	39,360.7	116.4	(17,659.7)	(6.3)
Ашиглалтын зардал	123,481.7	128,040.0	133,168.6	9,686.9	107.8	5,128.6	3.9
Түрээсийн зардал	680,831.3	1,200,000.0	4,044,685.4	3,363,854.1	594.1	2,844,685.4	70.3
Тос, тосолгооны зардал	81,406.6	89,639.0	68,831.1	(12,575.5)	84.6	(20,807.9)	(30.2)

Хөдөлмөр хамгаалалын зардал	33,490.0	34,760.0	22,391.9	(11,098.1)	66.9	(12,368.1)	(55.2)
Түүхий эд материал	3,488,401.5	5,076,970.0	4,054,263.9	565,862.4	116.2	(1,022,706.1)	(25.2)
Урсгал засварын зардал	13,698.9	180,000.0	40,000.0	26,301.1	292.0	(140,000.0)	(350.0)
Шатахуун	1,306,417.7	1,492,105.0	1,289,912.9	(16,504.8)	98.7	(202,192.1)	(15.7)
Шуудан холбоо, бичиг хэрэгсэл	15,857.4	31,283.0	29,355.3	13,497.9	185.1	(1,927.7)	(6.6)
Сургалт	17,890.0	10,210.0	7,195.0	(10,695.0)	40.2	(3,015.0)	(41.9)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	869,637.5	873,875.3	624,787.9	(244,849.6)	71.8	(249,087.4)	(39.9)
Албан журмын даатгал,татвар	24,927.2	37,000.0	21,395.8	(3,531.4)	85.8	(15,604.2)	(72.9)
Хангамжийн материал	40,432.9	46,118.8	27,354.5	(13,078.4)	67.7	(18,764.3)	(68.6)
Нийгмийн арга хэмжээний зардал	189,610.5	223,000.0	48,078.6	(141,531.9)	25.4	(174,921.4)	(363.8)
Ахмадын сан	33,583.0	50,721.3	13,600.0	(19,983.0)	40.5	(37,121.3)	(273.0)
Зар сурталчилгаа	-	5,500.0	1,500.0	1,500.0		(4,000.0)	(266.7)
Он дамнасан ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	28,655,142.2	25,937,307.4	21,260,509.3	(7,394,632.9)	74.2	(4,676,798.1)	(22.0)
2025 оны гэрээт ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	-	4,941,700.0	9,842,522.6	9,842,522.6		4,900,822.6	49.8
Гамшгийн үеийн менежментийн зардал	23,560.0	24,025.0	19,025.0	(4,535.0)	80.8	(5,000.0)	(26.3)
Үйл ажиллагааны бус зардал	22,236.7	60,000.0	18,900.0	(3,336.7)	85.0	(41,100.0)	(217.5)
Нийт зардлын дүн	**39,396,571.5**	**47,104,616.8**	**46,509,745.6**	**7,113,174.1**	**118.1**	**(594,871.2)**	**(1.3)**

Татварын өмнөх ашиг	**42,875.6**	**44,534.5**	**26,606.4**	**(16,269.2)**	**62.1**	(17,928.1)	**(67.4)**
Орлогын татвар	6,078.6	4,453.5	2,645.0	(3,433.6)	43.5	(1,808.5)	(68.4)
Цэвэр ашиг, алдагдал	**36,797.0**	**40,081.1**	**23,961.4**	**(12,835.6)**	**65.1**	(16,119.7)	**(67.3)**
Орлогын нэг төгрөгт ногдох зардал	**1.0**	**1.0**	**1.0**	(0.0)	99.9	(0.0)	(0.0)
Нийт авлага	4,000,283.0	3,123,383.0	8,042,833.3	4,042,550.3	201.1	4,919,450.3	61.2
Нийт өр төлбөр	4,021,017.0	4,348,160.0	7,502,261.5	3,481,244.5	186.6	3,154,101.5	42.0
Хөрөнгө орулалт	560,000.0	712,000.0		(560,000.0)		(712,000.0)	

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр 46,536,352.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 46,509,745.6 мянган төгрөгийн зардал гарган 26,606.4 мянган төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 47,149,151.2 мянган төгрөг болж төлөвлөснөөс 612,799.2 мянган төгрөг буюу 1.3 хувиар тасарсан нь “сургууль орчмын хөдөлгөөний аюулгүй байдал”-ын гэрээт ажил хэрэгжээгүйгээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 47,104,616.7 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 594,871.2 мянган төгрөг буюу 1.2 хувиар дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь он дамнасан ажлын бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал гол нөлөө үзүүлсэн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тайлант онд ногдол ашгийн 17,364.7 мянган төгрөгийг төвлөрүүлжээ.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Улаанбаатар зам засвар арчлалтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 01ны А/05 тушаалаар хоолны мөнгө 8.0 мянган төгрөгөөр, Унааны мөнгө 2.0 мянган төгрөгөөр тогтоосон байна.
- 2019 оноос эхлэн Интерактив Би Ай ХХК-ийн Diamond програм хангамжийг нягтлан бодох бүртгэлийг, Payroll програм хангамжийг цалингийн бүртгэлийг хөтлөж байна. Тайлант жилд засвар сайжруулалтын хөлсөнд 698.6 мянган төгрөг зарцуулсан гүйцэтгэлтэй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны бүртгэл

Тайлангийн хугацаанд Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 289,000.0 мянган төгрөгөөр авто замын зураг төсөл боловсруулах ажил үйлчилгээ, 1,450,000.0 мянган төгрөгийн шатах, тослох материал, 3,750,000.0 мянган төгрөгийн битум худалдан авч, 41,744.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг шууд худалдан авсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ай Жэй Эй Эйч аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Бэлэгт, аудиторын туслах Э.Нандин-Эрдэнэ нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Р.Алтанцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, дараагийн шатны чанарын хяналтыг Санхүүгийн аудитын албаны аудитын менежер С.Гантөгс, санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр, дарга, тэргүүлэх аудитор Г.Нандинжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ нь 2025 оны санхүүгийн тайланг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 44 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны жилийн эцсийн нийт зардлын 39,396,571.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 393,965.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөв зардлыг хэмнэж, цалин хөлсийг ажлын гүйцэтгэлээр олгож ажилласан боловч дараах зөрчил байна. Үүнд:

Тайлант онд спортын тэмцээний үйл ажиллагаанд 4,932.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-т *“Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”* 15.1.8-д *“Байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Спортын тэмцээн уралдаанд зарцуулсан 4,932.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант оны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Шилэн дансанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 376,755.3 мянган төгрөгийн 16 мэдээллийг, орлогын 67,678.7 мянган төгрөгийн 4 мэдээллийг, нийт 444,434.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Мөн PDF файлаар оруулах Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал, Үнэлгээний хорооны ашиг, сонирхлын мэдүүлэг, Худалдан авах ажиллагаатай холбоотой тендерийн мэдээлэл, Ажил гүйцэтгэх гэрээнүүдийг тус тус шилэн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.1-т *“Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”*, 4.1.3-т *“Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйл 6.2.2-т *“Орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/”*, 6.4.5-т “Ц*алингийн зардлаас бусад таван мянган төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Шилэн дансанд мэдээллийг байршуулаагүй зөрчилийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүллээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар бусад хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил байхгүй байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланг аудитад хамруулж 39,044,139.8 мянган төгрөгийн 7 алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар давтан үнэлж 39,044,139.8 мянган зөрчлийг арилгаж, шийдвэрийг хэрэгжүүлсэн тул 39,044,139.8 мянган төгрөгийн зөрчлийг залруулгаар тусгалаа.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 418,275.6 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 3,046,675.0 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 2 зөвлөмжийг хүргүүлжээ. Зөвлөмжийн хэрэгжилт 100 хэрэгжсэн байна.

Хүснэгт 4. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	3,046,675.0	2	3,046,675.0	100
Албан шаардлага	2	418,275.6	2	418,275.6	100
Нийт дүн	**4**	**3,464,950.6**	**4**	**3,464,950.6**	**100**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Худалдан авах үйл ажиллагаа болон ажил үйлчилгээг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллаж байгаа эсэхэд дараагийн тайлант хугацаанд анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,475,498.0 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 1,475,498.0 мянган төгрөгийн алдааг залруулав.

Залруулсан алдаа:

Нийслэлийн засаг даргын А/1528 дугаарт захирамжийн дагуу 1,475,498.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг төрийн өмч дээр бүртгэж авсан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 20 буюу Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын туслалцааны тодруулгыг хангахгүй тул залруулав.

Нийт илрүүлсэн 157,366.3 мянган төгрөгийн зөрчлийн дүн бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 236,599.0 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.2 АЛБАН ШААРДЛАГА

***Илрүүлэлт 1*:** Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 41,744.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т *“Захиалагч ерөнхий гэрээний аргаар худалдан авахаас бусад тохиолдолд хуульд заасан төсөвт өртөгт үндэслэн тендер шалгаруулалтын дараах аргын аль нэгийн дагуу зохион байгуулна"*, Засгийн газрын 2024 оны *“Худалдан авах ажиллагаанд бариимтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай”* 02 дугаар тогтоолтой тус тус нийцхгүй, санхүүгийн тайлагналын *“нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг”* батламж мэдэгдлийг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

***Илрүүлэлт 2*:** Тайлант хугацаанд 68,150.9 мянган төгрөгийн өглөг дансны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д *“Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 20.2.6-д *“Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, бариимтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 ЗӨВЛӨМЖ

***Илрүүлэлт 1*:** Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүнг ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүнтэй тулгахад ерөнхий журналд 47,470.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *"Анхан шатны бариимтын бүрдэлгүй ажил гүйлгээг, бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,* Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д *"Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо*

хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж, хүчин төгөлдөр баримтад үндэслэн ажил гүйлгээг бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт 2026 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийслэлийн засаг даргын А/1528 дугаарт захирамжийн дагуу 1,475,498.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг төрийн өмч дээр бүртгэж авсан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 20 буюу Засгийн газрын буцалтгүй тусламжийн нягтлан бодох бүртгэл ба Засгийн газрын туслалцааны тодруулгыг хангахгүй тул залруулав.	1	1,475,498.0			1	1,475,498.0	1	1,475,498.0		
Дүн	**1**	**1,475,498.0**			**1**	**1,475,498.0**	**1**	**1,475,498.0**		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим төлбөрийн системд бүртгэгдсэн нийт худалдан авалтын нэмэгдсэн өртгийн татварын дүн, Ерөнхий журналд тусгасан худалдан авалтын дүн 47,470.9 мянган төгрөгийн зөрүүтэй байна.	1	47,470.9					1	47,470.9				

Тайлант хугацаанд 68.150.9 мянган төгрөгийн өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	68,150.9			1	68,150.9						
Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй 41,744.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	41,744.5			1	41,744.5						
Дүн	**3**	**157,366.3**			**2**	**109,895.4**	**1**	**47,470.9**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	**Нийт зөрчил**		**Үүнээс**					
			Төлбөрийн акт		**Албан шаардлага**		**Зөвлөмж**	
	Тоо	**Дүн**	**Тоо**	**Дүн**	**Тоо**	**Дүн**	**Тоо**	**Дүн**
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 376,755.3 мянган төгрөгийн 16 мэдээллийг, орлогын 67,678.7 мянган төгрөгийн 4 мэдээллийг, нийт 444,434.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Мөн PDF файлаар оруулах Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, Хөрөнгө, мөнгө захиран зарцуулах тушаал, Үнэлгээний хорооны ашиг, сонирхлын мэдүүлэг, Худалдан авах ажиллагаатай холбоотой тендерийн мэдээлэл, Ажил гүйцэтгэх гэрээнүүдийг шилэн дансанд байршуулаагүй байна.	1	444,434.0			1	444,434.0		
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тайлант онд спортын тэмцээний үйл ажиллагаанд 4,932.0 мянган төгрөг зарцуулсан байна.	1	4,932.0	1	4,932.0				
Дүн	**2**	**449,366.0**	**1**	**4,932.0**	**1**	**444,434.0**		